

**МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ
ҮНЭЛСЭН СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

**УЛААНБААТАР ХОТ
2017 ОН**

МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ СУДАЛГАА

НЭГ.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэхүү судалгааны ажлын гол зорилго нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зарим зохицуулалт /зүйл, хэсэг, заалт/-д тодорхой шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хуулийн зохицуулалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулах, хуулийн төслийн чанарыг сайжруулахад оршино.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл/цаашид “хуулийн төсөл” гэх/-ийн зарим зохицуулалтын үр нөлөөг үнэлэхдээ Хууль тогтоомжийн тухай хууль, “Хуулийн төслийн үр нөлөө үнэлэх аргачлал”¹ /цаашид “аргачлал” гэх/-д заасны дагуу дараахь үе шаттайгаар хийлээ:

- 1.1.Шалгуур үзүүлэлтийг сонгох;
- 1.2.Хуулийн төслөөс үр нөлөө үнэлэх хэсгээ тогтоох;
- 1.3.Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
- 1.4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

ХОЁР.ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ

Тус судалгааны ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан аргачлалд дурдсан нийт 6 шалгуур үзүүлэлтээс дараахь 4 шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

- 2.1.Зорилгод хүрэх байдал
- 2.2.Практикт хэрэгжих боломж
- 2.3.Ойлгомжтой байдал
- 2.4.Харилцан уялдаа.

Дээрх шалгуур үзүүлэлтийг тухайлан сонгох болсон үндэслэл нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үндсэн зорилго, зохицуулах харилцааны онцлогтой холбоотой.

Тодруулбал, Ази-номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгээс Монгол Улсын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоонд хийсэн

¹ Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.1-д заасны дагуу 2016 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн Монгол Улсын Засгийн газрын 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан.

Харилцан үнэлгээний тайлантай /цаашид “Харилцан үнэлгээний тайлан” гэх/ холбогдуулан манай улсын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хууль, эрх зүйн орчинг сайжруулах зорилгоор гаргасан зөвлөмжийн дагуу хуулийн төсөлд өөрчлөхөөр болон шинээр тусгахаар заасан зохицуулалт нь зөвлөмжийн шаардлагыг хангасан эсэхийг тогтоох, ялангуяа Монголбанкны санхүүгийн мэдээллийн албаны үйл ажиллагааны чадамжийг бэхжүүлсэн эсэх, НҮБ-ын Аюулгүй зөвлөлөөс гаргасан хориг арга хэмжээг хэрэгжүүлэх хууль, эрх зүйн орчинг бий болгосон эсэх, мөн зөвлөмжийн зорилгод нийцүүлэн тусгасан зохицуулалт нь хэрэгжүүлэх боломжтой, тодорхой тусгасан эсэх, харилцан уялдаа бүхий бусад хуультай уялдсан эсэхэд дүн шинжилгээ хийх нь зүйтэй гэж үзэн дээрх 4 шалгуур үзүүлэлтийг сонголоо.

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтүүдийн хүрээнд хуулийн төслийн үзэл баримтлалд дурдсан Харилцан үнэлгээний тайланд заасны дагуу энэ чиглэлийн хууль эрх зүйн орчинг сайжруулах талаар Олон улсын валютын сан, Ази-номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгээс манай улсад өгсөн зөвлөмжийг хангах үндсэн зорилгод нийцсэн эсэх асуудлыг, “Практикт хэрэгжих боломж” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг хэрэгжүүлэх бодит боломж байгаа эсэх, хэрэгжүүлэх этгээд нь тодорхой эсэх асуудлыг, “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт ойлгомжтой, логик дараалалтайгаар боловсруулагдсан эсэх асуудлыг тус тус судалж, боломжит хувилбарыг тодорхойлохыг зорьсон.

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зүйл, хэсэг, заалт нь өөр хоорондоо болон Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Терроризмтой тэмцэх тухай хууль, Хууль тогтоомжийн тухай хууль, Банкны тухай хууль зэрэг бусад холбогдох хууль тогтоомжтой нийцсэн эсэх, бусад төрийн байгууллагын чиг үүрэгтэй давхардсан, зөрчилдсөн эсэх асуудлыг аргачлалд заасан асуултад хариулах байдлаар үнэлгээг хийхээр тооцов.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалд дурдсаны дагуу энэхүү арга хэмжээ нь олон улсаас манай улсад хүлээлгэсэн зайлшгүй хийгдэх ажлууд байх ба Олон улсын валютын сангаас тавьсан шаардлагын дагуу өөрсдийн нөөц бололцооны хүрээнд хийхээр хуулийн төслийн үзэл баримтлалд дурдсан байх тул Хүлээн зөвшөөрөгдөх байдал, Зардал тооцох шалгуур үзүүлэлтийг тус тус сонгоогүй болно.

ГУРАВ.ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

Аргачлалд заасны дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгосон тул түүнд хамаарах үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоохдоо хуулийн төслийн үзэл баримтлалд дурдсан хамгийн чухал, ач холбогдолтой зүйл, хэсэг, заалтыг² сонголоо:

² Хуулийн төслийн зүйл, хэсэг, заалтыг дурдахдаа үнэлгээний тайлан уншихад ойлгомжтой байлгах зорилгоор “... хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийн дугаарлалтаар бус, харин хуулийн төсөл батлагдсан тохиолдолд тухайн хуульд тусах үндсэн дугаарлалтыг үнэлгээний тайланд бичсэн болно.

№	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг
3.1.	Зорилгод хүрэх байдал	1.2.Энэ хуульд заасан терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх талаарх зохицуулалт үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх аливаа ажиллагаанд нэгэн адил хамаарна.
		3.1.7.“халхавч банк” гэж гүйцэтгэх удирдлага болон үйл ажиллагаа нь тухайн зөвшөөрөл авсан, эсхүл бүртгүүлсэн улсдаа бодитоор оршин байдаггүй, эсхүл тусгай зохицуулалттай ба нэгдсэн хяналт шалгалтад хамрагддаг санхүүгийн байгууллагад хамааралгүй банкийг;
		3.1.11.“үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх” гэж Монгол Улсын олон улсын гэрээгээр хориглосон хими, биологийн, эсхүл үй олноор устгах бүх төрлийн зэвсгийг боловсруулах, үйлдвэрлэх, хуримтлуулах, олж авах, худалдах үйл ажиллагаанд зарцуулагдахыг мэдсээр байж шууд, эсхүл шууд бусаар эд хөрөнгө хуримтлуулсан, шилжүүлсэн, зарцуулсныг.
		4.1.7.харилцагчийн нэрийн өмнөөс үл хөдлөх хөрөнгө худалдан авах, эсхүл худалдах аливаа ажиллагаа явуулсан бол үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага;
		5.10.Дараахь төрлийн харилцагчийг өндөр эрсдэлтэй харилцагчийн нэгэн адил авч үзнэ: 5.10.1.улс төрд нөлөө бүхий этгээд; 5.10.2.мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиг үүрэг бүхий олон улсын байгууллагаас мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хяналтын хангалтгүй тогтолцоотой гэж тодорхойлогдсон улсын хүн, хуулийн этгээд; 5.10.3.мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний эрсдэлийн үнэлгээгээр өндөр эрсдэлтэй гэж үнэлэгдсэн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа хүн, хуулийн этгээд.
		6¹ дүгээр зүйл.Нэгдсэн үндэстний байгууллагын Аюулгүй зөвлөл болон төрийн холбогдох байгууллагаас гаргасан

		хориг арга хэмжээг хэрэгжүүлэх 6¹.1.Энэ хуулийн 4.1-д заасан этгээд нь Нэгдсэн үндэстний байгууллагын Аюулгүйн зөвлөл болон төрийн холбогдох байгууллагын гаргасан хориг арга хэмжээний жагсаалт/цаашид “хориг арга хэмжээний жагсаалт” гэх/-д орсон хүн, хуулийн этгээд, аливаа бүлэг, нэгдэлтэй холбоотой шинээр данс нээх, аливаа үйлчилгээ үзүүлэхийг хориглоно. 6¹.2.Энэ хуулийн 4.1-д заасан этгээд нь хориг арга хэмжээний жагсаалтад орсон хүн, хуулийн этгээд, аливаа бүлэг, нэгдлийг мэдсэн даруй холбогдох данс, хөрөнгө, орлогын хөдөлгөөнийг даруй зогсоож, холбогдох байгууллагын шийдвэргүйгээр гүйлгээ хийх эрхгүй болгож Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлнэ. 6¹.3.Хориг арга хэмжээний жагсаалтыг мэдээлэх үүрэгтэй этгээдэд хүргэх, хэрэгжүүлэх, авсан арга хэмжээний тайлан гаргах, хуульд заасан арга хэмжээг авч хэрэгжүүлэх үйл ажиллагааг нарийвчилсан журмаар зохицуулна. 6¹.4.Энэ хуулийн 4.1-д заасан этгээд нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиг үүрэг бүхий олон улсын байгууллагаас мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хяналтын хангалтгүй тогтолцоотой гэж зарлагдсан улс орон, нутаг дэвсгэрийн харилцагч нарт өндөржүүлсэн харилцагчийг таньж мэдэх арга хэмжээ авах ба шаардлагатай бол хариу арга хэмжээ авна.
3.2.	Практикт хэрэгжих боломж	4.1.8.энэ хуулийн 5.1.2-т заасан мөнгөн дүн бүхий аливаа харилцаанд оролцсон бол үнэт металл, эсхүл үнэт чулууны болон тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч; 4.1.9.нотариатч, хуульч, эсхүл нягтлан бодох бүртгэл болон санхүүгийн менежментийн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа эрхлэгч / цаашид “нягтлан бодогч” гэх/ харилцагчийн нэрийн өмнөөс дараахь ажиллагааг хийсэн бол: 4.1.9.а.үл хөдлөх хөрөнгө худалдах, эсхүл худалдан авах; 4.1.9.б.харилцагчийн мөнгө, үнэт цаас, эсхүл бусад хөрөнгийг захиран зарцуулах; 4.1.9.в.банкны, хадгаламжийн, эсхүл үнэт цаасны дансыг удирдах;

		4.1.9.г.хуулийн этгээдийг үүсгэн байгуулах, түүний үйл ажиллагаа явуулах, удирдах, худалдах, худалдан авах; 4.1.9.д.хэлцлийн үндсэн дээр хөрөнгө удирдах, худалдах, худалдан авах. 4¹ дүгээр зүйл.Эцсийн өмчлөгчийг тогтоох 4¹.1.Эцсийн өмчлөгчийг дараахь дарааллаар шалгаж тогтооно: 4¹.1.1.хяналтын багцыг эзэмшиж байгаа, эсхүл бусад аргаар хяналтаа хэрэгжүүлж байгаа; 4¹.1.2.хуулийн этгээдийн үйлдэл, үйл ажиллагааг удирдаж, өөрийн үйлдлийг бусдаар төлөөлүүлэн хийлгэж байгаа; 4¹.1.3.өмнөх мэдээллийг тогтоох боломжгүй бол хуулийн этгээдийг удирдлагыг хэрэгжүүлэгч хүнийг. 4¹.2.Эцсийн өмчлөгчийг тогтоох талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээг нарийвчилсан журмаар зохицуулна. 5.9.Энэ хуулийн 4.1-д заасан этгээд нь дараахь тохиолдолд харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг энэ хуулийн 5.2.1, 5.2.2-д зааснаар хязгаарлан хялбаршуулсан хэлбэрээр харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг хийж болно: 5.9.1.харилцагч нь төрийн захиргааны байгууллага, орон нутгийн засаг захиргааны байгууллага, хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компани бол; 5.9.2.нийгмийн халамж, тэтгэвэр, тэтгэмжийн үйлчилгээг харилцагчид хүргэх зорилгоор данс нээх, гүйлгээ хийх. 14 дүгээр зүйл.Мэдээлэх үүрэгтэй этгээдийн дотоод хяналт 19 дүгээр зүйл.Мэдээлэх үүрэгтэй этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих
3.3.	Ойлгомжтой байдал	1.2.Энэ хуульд заасан терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх талаарх зохицуулалт үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх аливаа ажиллагаанд нэгэн адил хамаарна. 3.1.11.“үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх” гэж Монгол

		Улсын олон улсын гэрээгээр хориглосон хими, биологийн, эсхүл үй олноор устгах бүх төрлийн зэвсгийг боловсруулах, үйлдвэрлэх, хуримтлуулах, олж авах, худалдах үйл ажиллагаанд зарцуулагдахыг мэдсээр байж шууд, эсхүл шууд бусаар эд хөрөнгө хуримтлуулсан, шилжүүлсэн, зарцуулсныг. 5.14.Дараахь нарийвчилсан арга хэмжээг тусгасан мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журмыг төсөв, санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Монголын хуульчдын холбооны ерөнхийлөгч нарын саналыг үндэслэн Монголбанкны Ерөнхийлөгч батална: 5.14.1.эцсийн өмчлөгчийг тогтоох талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ; 5.14.2.харилцагчийг таньж мэдэх нарийвчилсан үйл ажиллагаа; 5.14.3.эрсдэлийн үнэлгээний талаарх нарийвчилсан үйл ажиллагаа; 5.14.4.дотоод хяналтын хөтөлбөрийн талаар; 5.14.5.хориг арга хэмжээний жагсаалттай холбогдуулан авч хэрэгжүүлэх арга хэмжээ. 6¹ дүгээр зүйл.Нэгдсэн үндэстний байгууллагын Аюулгүй зөвлөл болон төрийн холбогдох байгууллагаас гаргасан хориг арга хэмжээг хэрэгжүүлэх 6¹.1.Энэ хуулийн 4.1-д заасан этгээд нь Нэгдсэн үндэстний байгууллагын Аюулгүйн зөвлөл болон төрийн холбогдох байгууллагын гаргасан хориг арга хэмжээний жагсаалт/цаашид “хориг арга хэмжээний жагсаалт” гэх/-д орсон хүн, хуулийн этгээд, аливаа бүлэг, нэгдэлтэй холбоотой шинээр данс нээх, аливаа үйлчилгээ үзүүлэхийг хориглоно. 6¹.2.Энэ хуулийн 4.1-д заасан этгээд нь хориг арга хэмжээний жагсаалтад орсон хүн, хуулийн этгээд, аливаа бүлэг, нэгдлийг мэдсэн даруй холбогдох данс, хөрөнгө, орлогын хөдөлгөөнийг даруй зогсоож, холбогдох байгууллагын шийдвэргүйгээр гүйлгээ хийх
--	--	---

		эрхгүй болгож Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлнэ. 6¹.3.Хориг арга хэмжээний жагсаалтыг мэдээлэх үүрэгтэй этгээдэд хүргэх, хэрэгжүүлэх, авсан арга хэмжээний тайлан гаргах, хуульд заасан арга хэмжээг авч хэрэгжүүлэх үйл ажиллагааг нарийвчилсан журмаар зохицуулна. 6¹.4.Энэ хуулийн 4.1-д заасан этгээд нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиг үүрэг бүхий олон улсын байгууллагаас мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хяналтын хангалтгүй тогтолцоотой гэж зарлагдсан улс орон, нутаг дэвсгэрийн харилцагч нарт өндөржүүлсэн харилцагчийг таньж мэдэх арга хэмжээ авах ба шаардлагатай бол хариу арга хэмжээ авна.
3.4.	Харилцан уялдаа	Хуулийн төсөл бүхэлдээ

ДӨРӨВ.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Аргачлалд заасны дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлт, үр нөлөөг үнэлэх хэсгийг тус тус тогтоож, тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараахь байдлаар тодорхойлоо:

Д/д	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
4.1	Зорилгод хүрэх байдал	- 1 дүгээр зүйлийн 1.2 дахь хэсэг, - 3 дугаар зүйлийн 3.1.7, 3.1.11 дэх заалт, - 4 дүгээр зүйлийн 4.1.7 дахь заалт, - 5 дугаар зүйлийн 5.10 дахь хэсэг, - 6¹ дүгээр зүйл	Зорилгод дүн шинжилгээ хийх: Хуулийн төслийн зохицуулалт нь төслийн үзэл баримтлалд дурдсан зорилгод нийцсэн эсэхэд дүн шинжилгээ хийнэ.
4.2.	Практикт хэрэгжих боломж	- 4 дүгээр зүйлийн 4.1.8, 4.1.9 дэх заалт, - 4¹ дүгээр зүйл, - 5 дугаар зүйлийн 5.9 дэх хэсэг, - 14 дүгээр зүйл, - 19 дүгээр зүйл	Практикт турших: Бодит байдалд шинээр зохицуулж буй чиг үүрэг, бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд одоогийн нөөц бололцоо хангалттай эсэх, хэрэгжүүлэх субъект тодорхой эсэхийг судална.

4.3.	Ойлгомжтой байдал	- 1 дүгээр зүйлийн 1.2 дэх хэсэг, - 3 дугаар зүйлийн 3.1.11 дэх хэсэг, - 5 дугаар зүйлийн 5.14 дэх хэсэг, - 6¹ дүгээр зүйл	Ойлгомжтой байдлыг шалгах: Хуулийн төслийн зохицуулалт ойлгомжтой, логик дараалалтай, хэл зүйн талаасаа зөв томъёологдсон эсэхийг аргачлалын асуултад хариулах хэлбэрээр судална.
4.4.	Харилцан уялдаа	Хуулийн төсөл бүхэлдээ	Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах: Хуулийн төслийн уялдаа хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалын хүрээнд судалж, хоорондын уялдаа холбоог аргачлалд заасан асуултад хариулах байдлаар шалгана.

4.1 Шалгуур үзүүлэлт: Зорилгод хүрэх байдал

“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгож авсан хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1.2 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.1.7, 3.1.11 дэх заалт, 4 дүгээр зүйлийн 4.1.7 дахь заалт, 5 дугаар зүйлийн 5.10 дахь хэсэг, 6¹ дүгээр зүйлийг тус тус сонгож, эдгээр зохицуулалт нь уг хуулийн төслийн зорилгод хүрэх боломжтой эсэхийг албан ёсны мэдээлэл, холбогдох баримтад тулгуурлан бодит байдалд зорилгод хүрэх боломжтой эсэхийг судалсан.

Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд Харилцан үнэлгээний тайлан, түүний үр дагаврын талаар дараахь товч тайлбарыг хийлээ.

2017 оны 07 дугаар сард Шри-Ланка улсын нийслэл Коломбо хотод зохион байгуулагдсан Ази номхон далайн бүсийн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн 20 дахь удаагийн хурлаар Харилцан үнэлгээний тайлангийн төслийг хэлэлцэн баталсан байх ба уг үнэлгээнд манай улсын хууль, эрх зүйн орчин, түүний хэрэгжилтийн байдлыг 2016 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн байдлаар авч үзсэн байна.

Ази номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгээс Харилцан үнэлгээний тайлантай холбогдуулан өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх “15 сарын эрчимжүүлсэн арга хэмжээ”-г авах үүргийг манай улсад хүлээлгэсэн ба авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх эхний тайлан мэдээг 2018 оны 1 дүгээр сард, сүүлийн тайлан мэдээг 2018 оны 9 сард тус байгууллагад хүргүүлнэ.

Энэхүү 15 сарын хугацаанд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан мэдээний үр дүнд Ази номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэг нь манай улсыг Санхүүгийн хориг арга хэмжээг хэрэгжүүлэх олон улсын байгууллага /цаашид “ФАТФ” гэх/-аас гаргадаг “мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлтэй, хамтын ажиллагаа өрнүүлэх боломжгүй улс, бүс нутаг”-ийг багтаасан хар жагсаалтад оруулах эсэх асуудлыг хэлэлцэнэ.

ФАТФ нь 2012 оны 2 сард Монгол Улсыг ФАТФ-ын зөвлөмжийг хэрэгжүүлдэггүй, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог сайжруулах шаардлагатай улсын жагсаалтад багтааж, манай улсын эсрэг зарим санхүүгийн хориг арга хэмжээг авч хэрэгжүүлж байсан удаатай. Одоогоор ФАТФ-ын хар жагсаалтад Хойд Солонгос, Иран гэсэн 2 улс багтдаг ба эдгээр улс нь НҮБ-ын Аюулгүй зөвлөлөөс гаргасан хориг арга хэмжээний жагсаалтад мөн багтсан байна.

Иймд дээрх 15 сарын хугацаанд авч хэрэгжүүлэх арга хэмжээ нь манай улсыг дээрх хар жагсаалтад багтах эрсдэлээс хамгаалахаас гадна манай улсын эдийн засаг, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллөөс хамгаалах чухал ач холбогдолтой байна.

4.1.1.Харилцан үнэлгээний тайлангийн 4 дүгээр бүлгийн 11/IO 11/-д Монгол Улс нь үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх талаар хангалттай хууль эрх зүйн орчингүй гэж үзсэн байх ба ФАТФ-ын зөвлөмжийн техникийн хэрэгжилтийг үнэлэх болон мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны үр дүнтэй байдлыг дүгнэх аргачлал³-ын /цаашид “ФАТФ-ын үнэлгээний аргачлал” гэх/ дагуу 7 дугаар зөвлөмжийн хэрэгжилтийг “хангалтгүй” гэж үнэлэхдээ “үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэх, түүнийг санхүүжүүлэхийг таслан зогсоох, устгах, урьдчилан сэргийлэх зорилготой санхүүгийн хориг арга хэмжээг хэрэгжүүлэх хууль эрх зүйн орчин байхгүй гэж үзсэн байна.

Манай улсын хувьд “үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх” үйлдлийг Эрүүгийн хуулиар гэмт хэрэгт тооцсон боловч “үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх” үйлдлийг гэмт хэрэгт тооцоогүй ба ФАТФ-ын зөвлөмжид “үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх, түүнийг санхүүжүүлэхтэй” тэмцэх талаар туссантай холбогдуулан шинээр бие даасан зохицуулалт хуульд тусгах хэрэгцээ, шаардлага үүссэн байна.

Хуулийн төсөлд энэхүү зөвлөмжийн биелэлтийг хангах зорилгоор “хуулийн терроризмтэй тэмцэх аливаа зохицуулалт нь үйл олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэхэд нэг адил хамаарах”-аар дараахь байдлаар тусгасан байна.

Хуулийн төслөөс:

1.2.Энэ хуульд заасан терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх талаарх зохицуулалт үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх аливаа ажиллагаанд нэгэн адил хамаарна.

Хуулийн зохицуулалтад “үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх” асуудлыг багтааснаар зөвлөмжийн биелэлтийг хангах зорилгод хүрэх боломжтой юм.

³ ФАТФ-ын зөвлөмжийн техникийн хэрэгжилтийг үнэлэх болон мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны үр дүнтэй байдлыг дүгнэх аргачлал, 2013 оны 02 сар

Хуулийн зорилтыг зохицуулсан 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг байхаар тусгажээ. Өөрөөр хэлбэл, хуулийн зорилт нь “мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах эрх зүйн үндсийг тогтоох”-оос гадна мөн “үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх нь “терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх”-д мөн адил хамаарна гэсэн агуулгаар тусгасан байна. Гэтэл хуулийн зорилт хэсэгт “терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх” гэснээс гадна “урьдчилан сэргийлэх” асуудлыг тусгасан байна.

Үүнээс дүгнэвэл, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх асуудалд хуулийн зохицуулалт хамаарах ба урьдчилан сэргийлэх асуудал хамаарахгүй байх боломжтой байна. Иймд терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх бүхий л зохицуулалтад “үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх” асуудлыг багтаан ойлгохоор илүү тодорхой зохицуулах шаардлагатай.

4.1.2.Дээрх зохицуулалттай уялдуулан хуулийн төслөөр хуулийн 3 дугаар зүйл буюу “хуулийн нэр томъёоны тодорхойлолт”-д “үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх” гэдэгт “Монгол Улсын олон улсын гэрээгээр хориглосон хими, биологийн, эсхүл үй олноор устгах бүх төрлийн зэвсгийг боловсруулах, үйлдвэрлэх, хуримтлуулах, олж авах, худалдах үйл ажиллагаанд зарцуулагдахыг мэдсээр байж шууд, эсхүл шууд бусаар эд хөрөнгө хуримтлуулсан, шилжүүлсэн, зарцуулсныг” ойлгохоор нэмж тусгасан байна.

Хуулийн төслөөс:

3.1.11. “үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх” гэж Монгол Улсын олон улсын гэрээгээр хориглосон хими, биологийн, эсхүл үй олноор устгах бүх төрлийн зэвсгийг боловсруулах, үйлдвэрлэх, хуримтлуулах, олж авах, худалдах үйл ажиллагаанд зарцуулагдахыг мэдсээр байж шууд, эсхүл шууд бусаар эд хөрөнгө хуримтлуулсан, шилжүүлсэн, зарцуулсныг.

Бактериологийн /биологийн/ болон токсины зэвсэг боловсруулах, үйлдвэрлэх, нөөцлөхийг хориглох, тэдгээрийг устгах тухай конвенц⁴, Химийн зэвсэг боловсруулах, үйлдвэрлэх, нөөцлөх болон хэрэглэхийг хориглох, түүнийг устгах конвенциор⁵ “үй олноор хөнөөх зэвсгийн бүх төрлийг хориглох, устгах” чиглэлд үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг гишүүн орнуудад үүрэг болгож, “үй олноор хөнөөх зэвсэг”-т “химийн, бактериологийн буюу биологийн, токсины зэвсэг зэрэг үй олноор устгах бүх төрлийн зэвсгийг хамруулсан байна.

Одоогоор манай улсад терроризмтэй тэмцэх асуудлыг Терроризмтой тэмцэх тухай хуулиар зохицуулж, хэрэгжилтэд тагнуулын байгууллага, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх асуудлыг Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулиар зохицуулж, хэрэгжилтэд Санхүүгийн мэдээллийн алба тус тус хяналт тавьж, террор үйлдэх, терроризмыг санхүүжүүлэх, эдгээрт бэлтгэх, уриалах,

⁴ 1972 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр баталж, 1972 оны 05 дугаар сарын 18-ны өдөр хүчин төгөлдөр болсон.

⁵ 1993 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр баталж, 1997 оны 07 дүгээр сарын 29-ний өдөр хүчин төгөлдөр болсон.

мөн үйл олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх зэрэг үйлдлийг Эрүүгийн хуулиар гэмт хэрэгт тооцон, ял оногдуулж байна.

2002 болон 2015 оны Эрүүгийн хуульд “үй олноор хөнөөх зэвсэг боловсруулах, үйлдвэрлэх, хуримтлуулах, олж авах, борлуулах” үйлдлийг гэмт хэрэг тооцон хариуцлага хүлээлгэхээр зохицуулсан боловч “үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх” үйлдлийг гэмт хэрэгт тооцоогүй байна.

Түүнчлэн Ази номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэг болон Батлан хамгаалах, аюулгүй байдлын судалгааны “Роял юнайтед сервис хүрээлэн”-ээс гаргасан “Үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх: Үзэл баримтлалын удирдамж/аргачлал болон Засгийн газруудад зориулсан загвар хууль”⁶-ийн 1 дүгээр бүлгийн 6 дугаар зүйлд үй олноор хөнөөх зэвсгээс гадна “тэдгээрийн түүхий эд, материал, эд зүйл, тоног төхөөрөмж, технологийг” мөн хамруулахаар тусгасан байна.

Иймд хуулийн төслөөр “үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх” асуудлыг “терроризмыг санхүүжүүлэх” асуудалтай адилтган хуулийн зохицуулалтад хамруулсантай уялдуулан хэрэгжилтэд хяналт тавих субъект нь Санхүүгийн мэдээллийн алба байх тул “үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх” асуудлыг “терроризм”-ын асуудалтай адилтган Терроризмтой тэмцэх тухай хуулийн зохицуулалтад хамруулан тагнуулын байгууллага хяналт тавих талаар дагаж гарах хуулийн төслийг дахин боловсруулах шаардлагатай байна.

Өөрөөр хэлбэл, Терроризмтой тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай дагаж гарах хуулийн төсөл боловсруулж, төсөлд “хуулийн терроризмтэй тэмцэх бүхий л зохицуулалтад үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй тэмцэх аливаа ажиллагаа нэг адил хамаарах” асуудлыг, мөн “үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх” гэдэгт юуг ойлгох талаар тусгах шаардлагатай.

Түүнчлэн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай дагаж гарах хуулийн төслийг дахин боловсруулж, “үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх” гэмт хэргийг шинээр тусгах, “террор үйлдэхийг санхүүжүүлэх” гэмт хэрэгтэй адилтган энэ гэмт хэргийг үйлдсэн хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэхээр тусгах нь зүйтэй юм.

Хуулийн төсөлд тусгасан нэр томъёоны тодорхойлолт болон дагаж гарах хуулийн төслүүдэд “үй олноор хөнөөх зэвсэг”-ээс гадна “тэдгээрийн түүхий эд, материал, эд зүйл, тоног төхөөрөмж, технологи”-ийг хамруулж тусгах нь зүйтэй байна.

4.1.3. Үүнээс гадна ФАТФ-ын 2, 7 дугаар зөвлөмжтэй холбогдуулан Харилцан үнэлгээний тайлангийн шууд хэрэгжилт 11-д заасан “НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн тогтоолд заасны дагуу үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх үйл ажиллагаатай холбоотой хувь хүн, этгээдүүдийг хөрөнгө цуглуулах, шилжүүлэх, ашиглахаас

⁶ Андрей Бергер, Анага Жоши. Үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх: Үзэл баримтлалын удирдамж/аргачлал болон Засгийн газруудад зориулсан загвар хууль, 55 дугаар хуудас, 2017 оны 07 сар

урьдчилан сэргийлэх” хүрээнд манай улс хангалтгүй⁷ үнэлгээ авсантай холбогдуулан Нэгдсэн үндэстний байгууллагын Аюулгүйн зөвлөл болон төрийн холбогдох байгууллагын гаргасан хориг арга хэмжээний жагсаалт /цаашид “хориг арга хэмжээний жагсаалт” гэх/-д орсон хүн, хуулийн этгээд, аливаа бүлэг, нэгдэлтэй холбоотой хориг арга хэмжээг хэрэгжүүлэх зохицуулалтыг шинээр тусгасан байна.

Хуулийн төслөөс:

6¹ дүгээр зүйл.Нэгдсэн үндэстний байгууллагын Аюулгүй зөвлөл болон төрийн холбогдох байгууллагаас гаргасан хориг арга хэмжээг хэрэгжүүлэх

6¹.1.Энэ хуулийн 4.1-д заасан этгээд нь Нэгдсэн үндэстний байгууллагын Аюулгүйн зөвлөл болон төрийн холбогдох байгууллагын гаргасан хориг арга хэмжээний жагсаалт/цаашид “хориг арга хэмжээний жагсаалт” гэх/-д орсон хүн, хуулийн этгээд, аливаа бүлэг, нэгдэлтэй холбоотой шинээр данс нээх, аливаа үйлчилгээ үзүүлэхийг хориглоно.

6¹.2.Энэ хуулийн 4.1-д заасан этгээд нь хориг арга хэмжээний жагсаалтад орсон хүн, хуулийн этгээд, аливаа бүлэг, нэгдлийг мэдсэн даруй холбогдох данс, хөрөнгө, орлогын хөдөлгөөнийг даруй зогсоож, холбогдох байгууллагын шийдвэргүйгээр гүйлгээ хийх эрхгүй болгож Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлнэ.

6¹.3.Хориг арга хэмжээний жагсаалтыг мэдээлэх үүрэгтэй этгээдэд хүргэх, хэрэгжүүлэх, авсан арга хэмжээний тайлан гаргах, хуульд заасан арга хэмжээг авч хэрэгжүүлэх үйл ажиллагааг нарийвчилсан журмаар зохицуулна.

6¹.4.Энэ хуулийн 4.1-д заасан этгээд нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиг үүрэг бүхий олон улсын байгууллагаас мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хяналтын хангалтгүй тогтолцоотой гэж зарлагдсан улс орон, нутаг дэвсгэрийн харилцагч нарт өндөржүүлсэн харилцагчийг таньж мэдэх арга хэмжээ авах ба шаардлагатай бол хариу арга хэмжээ авна.

ФАТФ-ын 7 дугаар зөвлөмжид заасны дагуу хориг арга хэмжээний жагсаалтад багтсан хүн, хуулийн этгээд, аливаа бүлэг, нэгдэлтэй холбоотой үйл ажиллагаа, ялангуяа санхүүгийн болон ажил хэргийн аливаа үйл ажиллагааг таслан зогсоох, тэдгээртэй холбоотой хөрөнгө, орлогыг цаг алдалгүйгээр царцаах, битүүмжлэх асуудлыг тусгасан нь дэвшилттэй боловч зөвлөмжид заасан “урьдчилан мэдэгдэлгүйгээр” царцаах, битүүмжлэх талаар тодорхой тусгах шаардлагатай байна.

Түүнчлэн хуулийн төслийн 5.10 дугаар зүйлийн 5.10.2-т “мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиг үүрэг бүхий олон улсын байгууллагаас мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хяналтын хангалтгүй тогтолцоотой гэж зарлагдсан улсын хүн, хуулийн этгээд”-ийг өндөр эрсдэлтэй харилцагчийн нэг адил авч үзэн харилцагчийг таньж мэдэх нарийвчилсан арга хэмжээ авахаар зохицуулсан байх ба хуулийн төслийн 6¹ дугаар зүйлийн 6¹.4 дэх хэсэгт “... өндөржүүлсэн харилцагчийг таньж мэдэх арга хэмжээ авах ба шаардлагатай бол хариу арга хэмжээ” авахаар тусгасан нь ойлгомжгүй байдлыг үүсгэхээр байх ба

⁷ Харилцан үнэлгээний тайлан, 65 дугаар хуудас, 2017 оны 09 сар.

зорилгод хүрэх байдлыг тодорхойгүй, зөрчилдөөн үүсгэх нөхцөлийг бүрдүүлсэн байх тул зохицуулалтуудыг уялдуулах шаардлагатай байна.

Өөрөөр хэлбэл, харилцагчийг таньж мэдэх нарийвчилсан үйл ажиллагаа, өндөржүүлсэн харилцагчийг таньж мэдэх арга хэмжээ гэх зэрэг ухагдахууныг тодорхой болгох шаардлагатай байна.

4.1.4.Хуулийн 3 дугаар зүйл буюу “хуулийн нэр томьёоны тодорхойлолт”-д “халхавч банк гэж аливаа нэг улсад бүртгэлтэй боловч тухайн улсдаа бодит байдлаар оршин байдаггүй банкийг” ойлгохоор зохицуулсан бол хуулийн төсөлд “гүйцэтгэх удирдлага болон үйл ажиллагаа” нь тухайн улсдаа бодитоор байдаггүй, мөн “тусгай зохицуулалттай ба нэгдсэн хяналт шалгалтад хамрагддаг санхүүгийн байгууллага”-д хамаардаггүй гэсэн шинжүүдийг нэмж тусгахаар зохицуулжээ.

Хуулийн төслөөс:

3.1.7. “халхавч банк” гэж гүйцэтгэх удирдлага болон үйл ажиллагаа нь тухайн зөвшөөрөл авсан, эсхүл бүртгүүлсэн улсдаа бодитоор оршин байдаггүй, эсхүл тусгай зохицуулалттай ба нэгдсэн хяналт шалгалтад хамрагддаг санхүүгийн байгууллагад хамааралгүй банкийг;

ФАТФ-ын үнэлгээний аргачлалын “Нэр томьёоны тайлбар” хэсэгт:

- халхавч банкийг тодорхойлохдоо “үйл ажиллагаа явуулж байгаа, эсхүл зөвшөөрөл олгосон улсдаа бодитоор оршдоггүй, үр дүн бүхий нэгдсэн хяналт шалгалтыг хэрэгжүүлдэг тусгай зохицуулалттай санхүүгийн бүлэгт хамаардаггүй банк” гэжээ. Түүнчлэн “бодитоор орших” гэдэгт тухайн улсад байрлаж, зохистой удирдлага болон менежменттэй байхыг ойлгох ба тухайн улсад төлөөлөгчийн газар эсхүл доод түвшний ажилтан байх нь бодитоор оршин тогтнож буйг илэрхийлэхгүй гэжээ.

Иймд хуулийн төслөөр хуулийн нэр томьёоны тодорхойлолтыг зөвлөмжид нийцүүлэн зөвлөмжийн хэрэгжилтийг хангах зорилгод нийцсэн байна.

4.1.5.ФАТФ-ийн 22 дугаар зөвлөмжид “Санхүүгийн бус бизнес болон мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч /цаашид “СББМҮҮ” гэх/ нар харилцагчийг таньж мэдэх” талаар арга хэмжээ авах тохиолдлыг тусгахдаа 22.1.b хэсэгт “үл хөдлөх хөрөнгийн зуучлагч нь харилцагчийн нэрийн өмнөөс үл хөдлөх хөрөнгө худалдах, худалдан авах үйл ажиллагаанд оролцож байгаа тохиолдолд” харилцагчийг таньж мэдэх арга хэмжээ авахаар заажээ.

Хуулийн төслөөс:

4.1.7. харилцагчийн нэрийн өмнөөс үл хөдлөх хөрөнгө худалдан авах, эсхүл худалдах аливаа ажиллагаа явуулсан бол үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага;

Харин хуульд мэдээлэх үүрэгтэй этгээдийг тусгахдаа “үл хөдлөх хөрөнгийн зуучлагч” гэж өргөн хүрээнд авч үзсэнийг өөрчлөн “харилцагчийн нэрийн өмнөөс үл

хөдлөх хөрөнгө худалдан авах, худалдах аливаа ажиллагаа явуулсан үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага” байхаар хуулийн төсөлд тусгасан нь зөвлөмжид нийцсэнээс гадна хэрэгжилтийг үр дүнтэй болгох, шаардлагагүй хэт өргөн хүрээний хяналтыг хязгаарласан нь дэвшилттэй байна.

4.1.6.Хуулийн 5 дугаар зүйлд заасан “харилцагчийг таньж мэдэх” зохицуулалтын хүрээнд “өндөр эрсдэлтэй харилцагч”-ийг тогтоохоос зохицуулсан.

Харин ФАТФ-ын үнэлгээний аргачлалын 12, 19 дүгээр зөвлөмжөөс гадна шууд хэрэгжилт 4-ийн 4.4-т “Санхүүгийн байгууллага, СББМҮҮ нар нь улс төрд нөлөө бүхий этгээд, корреспондент банк, шинэ технологи, шилжүүлгийн журам, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой санхүүгийн хориг арга хэмжээ авах, ФАТФ-аас зарласан өндөр эрсдэлтэй орноор тодорхойлсон зэрэг тохиолдолд нэмэгдүүлсэн болон тусгай арга хэмжээг ямар түвшинд авч байгаа” байдалд үнэлгээ хийсэн ба зөвлөмжийн дагуу зарим этгээдийг шууд өндөр эрсдэлтэй харилцагчийн нэг адил авч үзэн нарийвчилсан үйл ажиллагаанд хамруулахаар тусгажээ.

Хуулийн төслөөс:

5.10.Дараахь төрлийн харилцагчийг өндөр эрсдэлтэй харилцагчийн нэгэн адил авч үзнэ:

5.10.1.улс төрд нөлөө бүхий этгээд;

5.10.2.мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиг үүрэг бүхий олон улсын байгууллагаас мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хяналтын хангалтгүй тогтолцоотой гэж зарлагдсан улсын хүн, хуулийн этгээд;

5.10.3.мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний эрсдэлийн үнэлгээгээр өндөр эрсдэлтэй гэж үнэлэгдсэн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа хүн, хуулийн этгээд.

Хуулийн төсөлд улс төрд нөлөө бүхий этгээд, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиг үүрэг бүхий олон улсын байгууллагаас мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хяналтын хангалтгүй тогтолцоотой гэж тодорхойлогдсон улсын хүн, хуулийн этгээд, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний эрсдэлийн үнэлгээгээр өндөр эрсдэлтэй гэж үнэлэгдсэн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа хүн, хуулийн этгээд зэргийг хамруулахаар зохицуулж, ФАТФ-ын 12, 19 дүгээр зөвлөмжид нийцүүлсэн байна.

4.2.Шалгуур үзүүлэлт: Практикт хэрэгжих боломж

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд аргачлалын гарын авлагын 2.2-т заасны дагуу “хуулийн төслөөр шинээр бий болгож байгаа чиг үүрэг, эрх хэмжээ, бүрэн эрхийг хэрэгжүүлэх”-тэй холбоотой зохицуулалт буюу хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.8, 4.1.9 дэх заалт, 4¹ дүгээр зүйл, 5 дугаар зүйлийн 5.9 дэх хэсэг, 14, 19 дүгээр зүйлийг тус тус сонгож, эдгээрийн практикт хэрэгжих боломжийг бодитойгоор туршиад их хэмжээний зардал, цаг хугацаа шаардахаар байгаагаас гадна Ази

номхон далайн бүсийн мөнгө угаахтай тэмцэх бүлгээс тогтоосон “эрчимжүүлсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх” 15 сарын хугацаа нь 2018 оны 09 дүгээр сард дуусахаар байгаа, хуулийн төсөл боловсруулж, өргөн мэдүүлэх, батлуулахад багагүй хугацаа шаардлагатай байгаа зэргийг харгалзан бодит туршилт хийх нь цаг хугацааны хувьд боломжгүй гэж үзэн ФАТФ-ын зөвлөмж, албан ёсны мэдээлэл, бусад холбогдох баримт, судалгаанд тулгуурлан бодит байдалд хэрэгжих боломжтой эсэхийг судаллаа.

Ийнхүү судлахдаа дараахь асуудалд анхаарал хандууллаа:

1/хуулийн төслийн сонгон авсан зохицуулалтыг бодит байдалд хэрэгжүүлэх боломж бий эсэх, мөн хуулиас давуу эрх мэдэл тогтоосон эсэх;

2/хуулиар төслийн зохицуулалтыг хэрэгжүүлэх этгээд байгаа эсэх;

3/хэрэгжүүлэгч этгээдэд тухайн хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж, бололцоо /санхүү, хүний нөөц зэрэг/ байгаа эсэх.

4.2.1.ФАТФ-ын 22, 23 дугаар зөвлөмжид “СББМҮҮ нь 10 дугаар зөвлөмжид заасан харилцагчийг таньж мэдэх шаардлагыг дагаж мөрдөх”, “гүйлгээг мэдээлэх шаардлагатай” талаар тусгахдаа 22.1.(с), 23.1.(b)-д тус тус заасны дагуу 15 000 ам.доллартой тэнцэх, эсхүл түүнээс дээш хэмжээтэй бэлэн мөнгөний гүйлгээг харилцагчтай хийх бол “үнэт металл, үнэт чулууны болон тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч”-ийг мэдээлэх үүрэгтэй байхаар энэ зөвлөмжид заажээ.

Хуулийн төслөөс:

4.1.8.энэ хуулийн 5.1.2-т заасан мөнгөн дүн бүхий аливаа харилцаанд оролцсон бол үнэт металл, эсхүл үнэт чулууны болон тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч;

Дээрх зөвлөмжийн шаардлагыг хангахаар 4 дүгээр зүйлд заасан сэжигтэй гүйлгээний талаар Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй этгээдэд шинээр “үнэт металл, эсхүл үнэт чулууны болон тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч”-ийг тусгасан ба ийнхүү тусгахдаа Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т заасан буюу “20 сая төгрөг /түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют/, түүнээс дээш үнийн дүнтэй” аливаа харилцаанд орохдоо сэжигтэй гүйлгээний талаар мэдээлэх үүргийг хүлээлгэсэн байна.

Харин ФАТФ-ын 22, 23 дугаар зөвлөмжөөс харахад “үнэт металл, эсхүл үнэт чулууны болон тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч нь 15 000 ам.доллартой тэнцэх, эсхүл түүнээс дээш хэмжээтэй бэлэн мөнгөний гүйлгээ хийх тохиолдолд” хамаарахаар тусгасан байхад хуулийн төсөлд “20 сая төгрөг /түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют/, түүнээс дээш үнийн дүнтэй аливаа харилцаанд оролцох” тохиолдолд гэж хэт өргөн хүрээнд тусгасан байх тул “аливаа харилцаанд оролцсон” гэснийг “бэлэн мөнгөний гүйлгээ хийсэн” гэж өөрчлөх нь зөвлөмжид нийцэхээс гадна бодит байдалд хэрэгжих боломж нь илүү байна.

4.2.2.Түүнчлэн ФАТФ-ын 22, 23 дугаар зөвлөмжийн 22.1.(d), 23.1.(a)-д тус тус заасны дагуу “хуульч, нотариатч, бусад бие даасан хуулийн мэргэжлийн үйлчилгээ

үзүүлэгч, нягтлан бодогч нар нь харилцагчид зориулан дараахь үйл ажиллагаатай холбогдуулж гүйлгээнд бэлтгэхдээ, эсхүл гүйлгээ хийх үедээ 10 дугаар зөвлөмжид заасан харилцагчийг таньж мэдэх шаардлагыг дагаж мөрдөх, мөн гүйлгээг мэдээлэх” үүргийг хүлээсэн байхаар заажээ:

а/үл хөдлөх хөрөнгө худалдах, худалдан авах бол;
б/харилцагчийн мөнгөн хөрөнгө, үнэт цаас болон бусад хөрөнгийг удирдах бол;
в/банкны, хадгаламжийн болон үнэт цаасны дансыг удирдах бол;
г/компанийг үүсгэн байгуулах, түүний үйл ажиллагааг явуулах, удирдахад зориулан хөрөнгө татах, бүрдүүлэхийг зохион байгуулах бол;
д/хуулийн этгээдийг, эсхүл бусад эрх зүйн зохицуулалт бүхий этгээдийг үүсгэн байгуулах, түүний үйл ажиллагааг явуулах, удирдах бол, мөн аж ахуйн нэгжийг худалдан авах, худалдах бол.

Хуулийн төслөөс:

4.1.9.нотариатч, хуульч, эсхүл нягтлан бодох бүртгэл болон санхүүгийн менежментийн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа эрхлэгч / цаашид “нягтлан бодогч” гэх/ харилцагчийн нэрийн өмнөөс дараахь ажиллагааг хийсэн бол:

4.1.9.а.үл хөдлөх хөрөнгө худалдах, эсхүл худалдан авах;

4.1.9.б.харилцагчийн мөнгө, үнэт цаас, эсхүл бусад хөрөнгийг захиран зарцуулах;

4.1.9.в.банкны, хадгаламжийн, эсхүл үнэт цаасны дансыг удирдах;

4.1.9.г.хуулийн этгээдийг үүсгэн байгуулах, түүний үйл ажиллагааг явуулах, удирдах, худалдах, худалдан авах;

4.1.9.д.хэлцлийн үндсэн дээр хөрөнгө удирдах, худалдах, худалдан авах.

Нотариатын тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасны дагуу “нотариатч” гэж “нотариатчийн чиг үүргийг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэн гүйцэтгэж, нотариатын үйлчилгээний хөлс, орлогоор санхүүжин ажиллаж байгаа иргэнийг” ойлгохоор заасан нь нотариатч нь зөвхөн хувь хүн байхаар байна.

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3.1.1-т заасны дагуу “хуульч” гэж “хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй этгээдийг” ойлгохоор заасан ба хуульд заасны дагуу уг зөвшөөрлийг зөвхөн хувь хүнд олгохоор байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд “нягтлан бодогч” гэдэгт хэнийг ойлгох талаар тодорхой тусгаагүй боловч мэргэжлийн, мэргэшсэн, ерөнхий нягтлан бодогч гэх зэргээр ялгамжтай тусгасан зохицуулалтуудаас харахад эдгээр нь мөн хувь хүн байхаар байна.

Дээр дурдсан субъект нь нийтлэг байдлаар бус, зөвхөн зөвлөмжид заасан онцгой тохиолдолд мэдээлэх үүрэг хүлээж, харилцагчийг таньж мэдэх ажиллагаа явуулахаар байгааг хуулийн төсөлд тусгасан нь зөвлөмжийн шаардлагад нийцсэн байгаа боловч зөвлөмжид дурдсан “manage”, “management” зэрэг үгийг хуулийн төсөлд тусгахдаа “удирдах”, “захиран зарцуулах” гэх зэрэг ялгамжтай үг хэллэг хэрэглэснийг жигдлэх, түүнчлэн ФАТФ-ын 22 дугаар зөвлөмжийн 22.1.(d)-д “компанийг үүсгэн байгуулах, түүний үйл ажиллагааг явуулах, удирдахад зориулан

хөрөнгө татах, бүрдүүлэхийг зохион байгуулах бол” гэснийг “хуулийн этгээдийг үүсгэн байгуулах, түүний үйл ажиллагааг явуулах, удирдах, худалдах, худалдан авах” гэж, “хуулийн этгээд, эсхүл хуулийн дагуу аливаа бүлэг, нэгдлийг үүсгэн байгуулах, түүний үйл ажиллагааг явуулах, удирдах бол, мөн аж ахуйн нэгжийг худалдан авах, худалдах бол” гэснийг “хэлцлийн үндсэн дээр хөрөнгө удирдах, худалдах, худалдан авах бол” гэж агуулгын хувьд алдаатай тусгасныг зөвлөмжид нийцүүлэх шаардлагатай байна.

Харин мэдээлэх үүрэгтэй этгээдэд шинээр хамааруулж байгаатай холбогдуулан үйл ажиллагаанд хэн хяналт тавих асуудлыг хуулийн төслийн 19.1-д зааснаар зохицуулж, энэ хуулиар хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах ажлыг тус төрлийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих төрийн байгууллага, Санхүүгийн мэдээллийн албатай хамтран хэрэгжүүлэхээр тусган хэрэгжүүлэх субъектийг тодорхой болгосон байна.

4.2.3.ФАТФ-ын үнэлгээний аргачлалын “Нэр томьёоны тайлбар” хэсэгт “Эцсийн өмчлөгч гэдэг нь хуулийн этгээдийг эзэмшдэг, эсвэл түүний нэрийн өмнөөс гүйлгээ хийж буй харилцагч, хувь хүнийг хянадаг хувь хүнийг хэлнэ. Үүнд хуулийн этгээдийг болон бусад эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдэд үр дүнтэй эцсийн хяналт тавьдаг хувь хүн хамаарна.” гэж заажээ.

Хуулийн төслөөс:

4¹ дүгээр зүйл.Эцсийн өмчлөгчийг тогтоох

4¹.1.Эцсийн өмчлөгчийг дараахь дарааллаар шалгаж тогтооно:

4¹.1.1.хяналтын багцыг эзэмшиж байгаа, эсхүл бусад аргаар хяналтаа хэрэгжүүлж байгаа;

4¹.1.2.хуулийн этгээдийн үйлдэл, үйл ажиллагааг удирдаж, өөрийн үйлдлийг бусдаар төлөөлүүлэн хийлгэж байгаа;

4¹.1.3.өмнөх мэдээллийг тогтоох боломжгүй бол хуулийн этгээдийг удирдлагыг хэрэгжүүлэгч хүнийг.

4¹.2.Эцсийн өмчлөгчийг тогтоох талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээг нарийвчилсан журмаар зохицуулна.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.6-д эцсийн өмчлөгчийн талаарх ойлголтыг тусгасан ба уг тодорхойлолтын талаар Харилцан үнэлгээний тайланд дурдаагүй боловч эцсийн өмчлөгчийг тогтоох ажиллагааг хангалттай гэж үзээгүй байна.

Иймд ФАТФ-ын үнэлгээний аргачлалд заасны дагуу эцсийн өмчлөгчийг шалган тогтоох дарааллыг хуулийн төслөөр нэмж тусгасан байх боловч “бусад аргаар хяналтаа хэрэгжүүлж байгаа”, “өөрийн үйлдлийг бусдаар төлөөлүүлэн хийлгэж байгаа” зэргийн ялгамжтай байдлыг тогтооход хүндрэл үүсэхээр байна.

Энэ талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээг нарийвчилсан журмаар зохицуулахаар зааснаас гадна хуулийн төслийн хэд хэдэн хэсэгт журмаар зохицуулахаар тусгасан зохицуулалт байх боловч журмыг хэн батлах нь тодорхойгүй мэт. Гэвч хуулийн 5 дугаар зүйл буюу “харилцагчийг таньж мэдэх” талаарх зохицуулалтад дараахь агуулга бүхий шинэ хэсэг нэмэхээр хуулийн төсөлд тусгажээ:

Хуулийн төслөөс:

5.14.Дараахь нарийвчилсан арга хэмжээг тусгасан мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журмыг төсөв, санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Монголын хуульчдын холбооны ерөнхийлөгч нарын саналыг үндэслэн Монголбанкны Ерөнхийлөгч батална:

5.14.1.эцсийн өмчлөгчийг тогтоох талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ;

5.14.2.харилцагчийг таньж мэдэх нарийвчилсан үйл ажиллагаа;

5.14.3.эрсдэлийн үнэлгээний талаарх нарийвчилсан үйл ажиллагаа;

5.14.4.дотоод хяналтын хөтөлбөрийн талаар;

5.14.5.хориг арга хэмжээний жагсаалттай холбогдуулан авч хэрэгжүүлэх арга хэмжээ.

Үүнээс дүгнэвэл хуулийн төсөлд хэд хэдэн ажиллагааг нарийвчилсан журмаар зохицуулахаар зааж, хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.14 дэх хэсэгт эдгээр журмыг хэн батлах асуудлыг тусгасан байна.

Гэвч эдгээр нарийвчилсан журмыг нэгтгэн “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам” нэртэй нэг журам байх талаар зохицуулсан нь төдийлөн ойлгомжтой бус, зүйлүүд хоорондоо уялдаагүй байна.

Иймд хуулийн төсөлд журмаар зохицуулах талаар туссан зүйлүүдэд “хуулийн 5 дугаар зүйлийн 5.14 дэх хэсэгт заасан журамд хамаарах” талаар тодорхой тусгах нь оновчтой байна.

4.2.4.ФАТФ-ын 10 дугаар зөвлөмжийн 10.18-д “Санхүүгийн байгууллага нь хялбаршуулсан харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг зөвхөн нарийвчилсан судалгааны үндсэн дээр улс орон эсхүл санхүүгийн байгууллага өөрөө эрсдэл багатай гэдэг нь тодорхойлогдсон үед хийх боломжтой байх шаардлагатай” гэж заажээ.

Хуулийн төслөөс:

5.9.Энэ хуулийн 4.1-д заасан этгээд нь дараахь тохиолдолд харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг энэ хуулийн 5.2.1, 5.2.2-д зааснаар хязгаарлан хялбаршуулсан хэлбэрээр харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг хийж болно:

5.9.1.харилцагч нь төрийн захиргааны байгууллага, орон нутгийн засаг захиргааны байгууллага, хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат

компани бол;

5.9.2.нийгмийн халамж, тэтгэвэр, тэтгэмжийн үйлчилгээг харилцагчид хүргэх зорилгоор данс нээх, гүйлгээ хийх.

Хуулийн төсөлд хялбаршуулсан харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаа явуулахдаа хуулийн төслийн 5.1.1, 5.1.2-т зааснаар хязгаарлан хэрэглэхээр заажээ. Харин дээрх заалтуудаар мэдээлэх үүрэгтэй этгээдэд “бизнесийн харилцаа үүсгэхийн өмнө”, эсхүл “дансгүй, эсхүл санхүүгийн тогтвортой харилцаа үүсгээгүй этгээд тохиолдлын чанартайгаар 20 сая төгрөг /түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют/, түүнээс дээш үнийн дүнтэй гүйлгээ хийхийн өмнө” харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг хийх үүргийг хүлээлгэсэн.

Хуулийн төслөөс:

5.1.Дараах тохиолдолд энэ хуулийн 4.1-д заасан этгээд харилцагчийг албан ёсны эх сурвалж, баримт бичиг, мэдээ, мэдээллийн эх үүсвэр ашиглан таньж мэдэх үүрэгтэй:

5.1.1.бизнесийн харилцаа үүсгэхийн өмнө;

5.1.2.дансгүй, эсхүл санхүүгийн тогтвортой харилцаа үүсгээгүй этгээд тохиолдлын чанартайгаар 20 сая төгрөг /түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют/, түүнээс дээш үнийн дүнтэй гүйлгээ хийхийн өмнө;

Хуулийн төсөлд эдгээр заалтаар хязгаарлахаар заасан нь эдгээр заалтын хүрээнд, эсхүл эдгээр заалтаас бусад тохиолдолд эсэх нь ойлгомжгүй байгаа нь практикт хэрэгжүүлэх этгээдэд хүндрэл үүсгэхээр байна.

4.2.5.ФАТФ-ын 18 дугаар зөвлөмжид “Санхүүгийн байгууллага нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэл болон бизнесийн хэмжээг харгалзан үзэж боловсруулсан мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хэд хэдэн асуудлыг агуулсан дотоод бодлого, журам, хяналтыг агуулсан хөтөлбөртэй байх шаардлагатай”-г дурдсан.

Тухайлбал, дотоод хяналтын хөтөлбөр нь удирдлагын түвшинд хэрэгжилтийг хангах тогтолцоо, (удирдлагын түвшинд хэрэгжилтийн мэргэжилтэнг томилох асуудал, ажилтан шинээр ажилд сонгон шалгаруулж авахад шаардлагатай өндөр стандарт бүхий журам, ажилтны давтан сургах хөтөлбөр, үйл ажиллагааг хянах хөндлөнгийн аудитын чиг үүрэг, харилцагчийг таньж мэдэх болон мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн удирдах зорилгоор мэдээлэл солилцох бодлого, үүнийг зохицуулах журам, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх зорилгоор шаардлагатай бол салбар, харьяа нэгжүүдээс ирүүлэх гүйлгээний мэдээлэл, данс, харилцагч, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхтэй холбоотой зүйл заалтууд, аудит, хэрэгжилтийн талаар нэгдлийн хэмжээнд нөхцөлийг бүрдүүлсэн байх, солилцсон мэдээллийн нууцлал аюулгүй байдлыг шаардлагатай түвшинд хангах зэрэг асуудлыг агуулна.

Хуулийн төслөөс:

14 дүгээр зүйл.Мэдээлэх үүрэгтэй этгээдийн дотоод хяналт

14.1.Энэ хуулийн 4.1-д заасан этгээд нь түүний төлөөлөн удирдах зөвлөл, эхсүл түүнтэй дүйцэх удирдлагаас баталсан мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхэд чиглэсэн дотоод хяналтын хөтөлбөртэй байна.

14.2.Дотоод хяналтын хөтөлбөр нь энэ хуулийн 4.1-д заасан этгээдийн бизнесийн цар хүрээ, үйл ажиллагааны онцлог, бүтэц зохион байгуулалтад нийцсэн байх ба мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх зорилгоор үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэх боломжийг хангасан байна.

14.3.Дотоод хяналтын хөтөлбөрийг энэ хуулийн 4.1-т заасан этгээдийн харьяалагддаг санхүүгийн нэгдэл, тэдгээрийн бүх салбар нэгж, охин компани нь нэгэн адил хэрэгжүүлнэ.

14.4.Дотоод хяналт хөтөлбөрт дараахь асуудлыг тусгана:

14.4.1.харилцагч болон бүтээгдэхүүн, үйлчилгээ, тэдгээрийг харилцагчид хүргэх арга хэлбэрийн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг үнэлэх аргачлал;

14.4.2.өндөр эрсдэлтэй харилцагчийг нарийвчлан таньж мэдэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх журам;

14.4.3.шинэ технологи болон өндөр эрсдэлтэй бүтээгдэхүүн, үйлчилгээ, тэдгээрийг харилцагчид хүргэх арга хэлбэрийн эрсдэлийг бууруулахад чиглэсэн арга хэмжээ авах зохицуулалт;

14.4.4.харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааны журам;

14.4.6.харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэхэд дагаж мөрдөх зохицуулалт;

14.4.7.Нэгдсэн үндэстний байгууллагын Аюулгүйн зөвлөл болон төрийн холбогдох байгууллагын гаргасан хориг арга хэмжээг хэрэгжүүлэх зохицуулалт;

14.4.8.тусгайлан хяналт тавих үйл ажиллагааны журам;

14.4.9.гадаад улсын банкинд харилцах данс нээх журам /лоро данс, корреспондент банкны харилцаа тогтоох журам/;

14.4.10.мөнгө гуйвуулга, цахим төлбөр тооцоог гүйцэтгэхэд баримтлах журам;

14.4.11.сэжигтэй гүйлгээг илрүүлэх, мэдээллийн нууцлалыг хадгалах, Санхүүгийн мэдээллийн алба болон эрх бүхий бусад байгууллагад мэдээлэл өгөх, баримт бичиг шилжүүлэх, хадгалах журам;

14.4.12.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, дотоод хяналтын хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих ажилтныг томилох, чөлөөлөх журам, түүний эрх, үүрэг;

14.4.13.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, холбогдох бусад журмын хэрэгжилтийг хангахад чиглэсэн дотоод сургалтын хөтөлбөр.

14.5.Дотоод хяналтын хөтөлбөрийг энэ хуулийн 4.1-д заасан этгээд нь өөрийн харьяалагддаг хяналт шалгалтын байгууллагад хүргүүлж бүртгүүлнэ.

14.6.Энэ хуулийн 4.1-д заасан этгээдийн төлөөлөн удирдах зөвлөл болон түүний дэргэдэх хороо, эхсүл бие даасан дотоод хяналтын нэгжээр дамжуулан дотоод хяналтын хөтөлбөрийн үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавьж шаардлагатай өөрчлөлтийг хийнэ.

Мэдээлэх үүрэгтэй этгээд дотоод хяналтын хөтөлбөртэй байхаар хуульд туссан боловч Харилцан үнэлгээний тайлангаас⁸ харахад “хуулийн зохицуулалтаар ФАТФ-ын зөвлөмжид заасан стандартыг хангалттай тусгаагүй гэж дүгнэсэн байна.

Иймд хуулийн төсөлд ФАТФ-ын 18 дугаар зөвлөмжид заасныг тусгасан байх ба дотоод хяналтын хөтөлбөрийг мэдээлэх үүрэгтэй этгээд нь өөрийн харьяалагддаг хяналт шалгалтын байгууллагад хүргүүлэхээр зохицуулсан байна. Харин хөтөлбөрийн үр дүнтэй байдалд хяналт тавих, шаардлагатай тохиолдолд өөрчлөлт оруулах асуудлыг мэдээлэх үүрэгтэй этгээдийн төлөөлөн удирдах зөвлөл, түүний дэргэдэх хороо, эхсүл бие даасан дотоод хяналтын нэгж зэрэг нь хяналт тавихаар тодорхой тусгасан байна.

4.2.6.ФАТФ-ын 29 дүгээр зөвлөмжид “улс орнууд сэжигтэй гүйлгээний тайлан, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон суурь гэмт хэрэгтэй холбоотой бусад мэдээллийг хүлээн авч, дүн шинжилгээ хийж, шинжилгээний үр дүнг шилжүүлэх үүрэг бүхий үндэсний төв болох Санхүүгийн мэдээллийн албыг байгуулах шаардлагатай” талаар тусгасан байна.

Хуулийн төслөөс:

19 дүгээр зүйл.Мэдээлэх үүрэгтэй этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих

19.1.Энэ хуулийн 4.1.1-д заасан этгээд энэ хуулиар хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах ажлыг Монголбанк, энэ хуулийн 4.1.2-4.1.7 дугаар заалтад заасан этгээд энэ хуулиар хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах ажлыг Санхүүгийн зохицуулах хороо, Санхүүгийн мэдээллийн албатай хамтран, энэ хуулийн 4.1.8-4.1.9 дүгээр заалтад заасан этгээд энэ хуулиар хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах ажлыг тус төрлийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих төрийн байгууллага, Санхүүгийн мэдээллийн албатай хамтран хэрэгжүүлнэ.

19.2.Энэ хуулийн хэрэгжилтэд хяналт тавихтай холбогдуулж холбогдох хяналт шалгалт хариуцсан төрийн байгууллага, Санхүүгийн мэдээллийн алба дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

19.2.1.энэ хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор энэ хуулийн 4.1-д заасан этгээдэд газар дээрх шалгалт хийх, зайнаас хяналт тавих журам, шалгалтын удирдамж, заавар, зөвлөмж гаргах;

19.2.2.энэ хуулийн 4.1-д заасан этгээдийн хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих зорилгоор баримт, тайлан, мэдээлэл, тайлбар гаргуулан авах;

19.2.3.санхүүгийн нэгдлийн хэмжээнд хуулийн хэрэгжилтийг шалгах шаардлагатай гэж үзвэл Монголбанк, төсөв, санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Санхүүгийн зохицуулах

⁸ Харилцан үнэлгээний тайлан, 121 дүгээр хуудас, 2017 оны 09 сар.

хороотой хамтран нэгдсэн хяналт шалгалтыг хийх;

19.2.4.санхүүгийн нэгдлийн оролцогч нь өөр улсад бүртгэгдсэн, эсхүл байршдаг бол холбогдох хяналт шалгалт хариуцсан байгууллага нь тухайн улсын хяналт шалгалт хариуцсан эрх бүхий байгууллагатай гэрээ, харилцан ойлголцлын санамж бичиг байгуулан мэдээлэл солилцох, хамтарсан шалгалт хийх хэлбэрээр хамтран ажиллах;

19.2.5.энэ хуулийн 4.1-д заасан этгээдийн хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангуулах, хяналт шалгалтын үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах зорилгоор холбогдох хяналт шалгалт хариуцсан байгууллага хоорондоо болон Санхүүгийн мэдээллийн албатай мэдээлэл солилцох, хамтран ажиллах;

19.2.6.энэ хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан авч байгаа арга хэмжээ болон хариуцлагын талаарх статистик мэдээг нийтэд түгээх.

19.3.Энэ хуулийн 4.1-д заасан этгээд, түүний эрх бүхий албан тушаалтан, ажилтан нь хянан шалгагчийг бүрэн эрхээ хэрэгжүүлэх, хяналт шалгалтын үйл ажиллагааг бие даасан, хараат бусаар явуулах нөхцөлөөр хангана.

Хуулийн төслөөр мэдээлэх үүрэгтэй этгээдийг зөвлөмжид нийцүүлэн нэмсэн ба үүнтэй холбогдуулан:

- банк энэ хуулиар хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах ажлыг Монголбанк,
- банк бус санхүүгийн байгууллага, даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогч, хөрөнгө оруулалтын сан, хөрөнгө оруулалтын менежментийн компани, үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага, хадгаламж, зээлийн хоршоо, үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага нь энэ хуулиар хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах ажлыг Санхүүгийн зохицуулах хороо, Санхүүгийн мэдээллийн албатай хамтран,
- үнэт металл, эсхүл үнэт чулууны болон тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч, нотариатч, хуульч, нягтлан бодогч нь энэ хуулиар хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах ажлыг тус төрлийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих төрийн байгууллага, Санхүүгийн мэдээллийн албатай хамтран

хэрэгжүүлэхээр зааж, практикт мэдээлэх үүрэгтэй этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих субъектийг тодорхой болгосноос гадна хуулийн хэрэгжилтэд хяналт тавихтай холбогдуулж Санхүүгийн мэдээллийн албанаас авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхой зохицуулсан байна.

4.3.Шалгуур үзүүлэлт: Ойлгомжтой байдал

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад хариулах байдлаар зохицуулалтыг хэрэгжүүлэх, хэрэглэх этгээдэд ойлгомжтой байдлаар томъёологдсон эсэхийг шалгах тул шалгах хэсгээ сонгохдоо хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1.2 дэх хэсэг, 3 дугаар

зүйлийн 3.1.11 дэх хэсэг, 5 дугаар зүйлийн 5.14 дэх хэсэг, 6¹ дүгээр зүйлийг тус тус сонгож, хуулийн төсөлд холбогдох бусад байгууллагаас одоогоор авсан санал байхгүй тул Хууль тогтоомжийн тухай хуулийн 29, 30 дугаар зүйлд заасан аргачлалын дагуу боловсруулагдсан эсэхийг шалган үнэллээ.

Хуулийн төслөөс:

1 дүгээр зүйл:

1.2.Энэ хуульд заасан терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх талаарх зохицуулалт үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх аливаа ажиллагаанд нэгэн адил хамаарна.

3 дугаар зүйл:

3.1.11.“үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх” гэж Монгол Улсын олон улсын гэрээгээр хориглосон хими, биологийн, эсхүл үй олноор устгах бүх төрлийн зэвсгийг боловсруулах, үйлдвэрлэх, хуримтлуулах, олж авах, худалдах үйл ажиллагаанд зарцуулагдахыг мэдсээр байж шууд, эсхүл шууд бусаар эд хөрөнгө хуримтлуулсан, шилжүүлсэн, зарцуулсныг.

5 дугаар зүйл:

5.14.Дараахь нарийвчилсан арга хэмжээг тусгасан мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журмыг төсөв, санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Монголын хуульчдын холбооны ерөнхийлөгч нарын саналыг үндэслэн Монголбанкны Ерөнхийлөгч батална:

5.14.1.эцсийн өмчлөгчийг тогтоох талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ;

5.14.2.харилцагчийг таньж мэдэх нарийвчилсан үйл ажиллагаа;

5.14.3.эрсдэлийн үнэлгээний талаарх нарийвчилсан үйл ажиллагаа;

5.14.4.дотоод хяналтын хөтөлбөрийн талаар;

5.14.5.хориг арга хэмжээний жагсаалттай холбогдуулан авч хэрэгжүүлэх арга хэмжээ.

6¹ дугаар зүйл:

6¹ дүгээр зүйл.Нэгдсэн үндэстний байгууллагын Аюулгүй зөвлөл болон төрийн холбогдох байгууллагаас гаргасан хориг арга хэмжээг хэрэгжүүлэх

6¹.1.Энэ хуулийн 4.1-д заасан этгээд нь Нэгдсэн үндэстний байгууллагын Аюулгүйн зөвлөл болон төрийн холбогдох байгууллагын гаргасан хориг арга хэмжээний жагсаалт/цаашид “хориг арга хэмжээний жагсаалт” гэх/-д орсон хүн, хуулийн этгээд, аливаа бүлэг, нэгдэлтэйхолбоотой шинээр данс нээх, аливаа үйлчилгээ үзүүлэхийг хориглоно.

6¹.2.Энэ хуулийн 4.1-д заасан этгээд нь хориг арга хэмжээний жагсаалтад орсон хүн, хуулийн этгээд, аливаа бүлэг, нэгдлийг мэдсэн даруйхолбогдох данс, хөрөнгө, орлогын хөдөлгөөнийг даруй зогсоож,холбогдох

байгууллагын шийдвэргүйгээр гүйлгээ хийх эрхгүй болгож Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлнэ.

6¹.3.Хориг арга хэмжээний жагсаалтыг мэдээлэх үүрэгтэй этгээдэд хүргэх, хэрэгжүүлэх, авсан арга хэмжээний тайлан гаргах, хуульд заасан арга хэмжээг авч хэрэгжүүлэх үйл ажиллагааг нарийвчилсан журмаар зохицуулна.

6¹.4.Энэ хуулийн 4.1-д заасан этгээд нь мөнгө угаах болон терроризмыгсанхүүжүүлэхтэй тэмцэх чиг үүрэг бүхий олон улсын байгууллагаас мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хяналтын хангалтгүй тогтолцоотой гэж зарлагдсан улс орон, нутаг дэвсгэрийн харилцагч нарт өндөржүүлсэн харилцагчийг таньж мэдэх арга хэмжээ авах ба шаардлагатай бол хариу арга хэмжээ авна.

Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавигдах нийтлэг шаардлага, хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавигдах нийтлэг шаардлагыг хангасан эсэхийг аргачлалд заасан асуултад хариулах байдлаар шалгалаа.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага	
Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт	Хуулийн төслийн зохицуулалтад үнэлгээ хийсэн байдал
29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх;	Үндсэн хуульд заасан зарчимтай зөрчилдөөгүй ба түүнийг хангахад чиглэсэн байна.
29.1.2.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Шаардлагыг хангасан байна.
29.1.3.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Шаардлагыг хангасан байна.
29.1.4.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;	Шаардлагыг хангасан байна.
29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Шаардлагыг хангасан байна.
29.1.6.хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Шаардлагыг хангасан байна.
29.1.7.бусад хуулийн заалтыг	Шаардлагыг хангасан байна..

давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг иш татах, энэ тохиолдолд ишлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	
29.1.8.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журам;	Шаардлагыг хангасан байна.
29.1.9.шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох, хасах заалт;	Шаардлагыг хангасан байна. Хууль зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг тусгах зорилгоор Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай дагаж гарах хуулийн төсөл боловсруулсан байна.
29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх;	Шаардлагыг хангасан байна. Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Терроризмтой тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай дагаж гарах хуулийн төсөл боловсруулсан байна.
29.1.11.хуулийн төсөл нь хуулийн зорилго гэсэн зүйлтэй байж болох бөгөөд зорилгод тус хуулиар хангахаар зорьж байгаа иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгана.	Шаардлагыг хангасан байна.
30 дугаар зүйл.Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага	
30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх;	Шаардлагыг хангасан байна.

30.1.2.нэг нэр томьёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;	Шаардлагыг хангасан байна.
30.1.3.үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	Шаардлагыг хангасан байна.
30.1.4.хүч оруулсан нэр томьёо хэрэглэхгүй байх;	Шаардлагыг хангасан байна.
30.1.5.жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.	Шаардлагыг хангасан байна.

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан зарчимтай зөрчилдөөгүй, түүнийг хангахад чиглэсэн байх бөгөөд бусад хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа хууль тогтоомжтой зөрчилдөөгүй, хуульд заасан шаардлагыг бүрэн хангасан байх ба Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал⁹ -ын дагуу хуулийн төслийг боловсруулсан байна.

4.4.Шалгуур үзүүлэлт: Хуулийн төслийн уялдаа холбоо

Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зүйл, хэсэг, заалт хоорондоо, эсхүл бусад хууль тогтоомжтой нийцэж байгаа болон давхардал, хийдэл, зөрчил байгаа эсэх, төрийн байгууллагын чиг үүрэг давхардсан, зөрчилдсөн эсэхийг тогтоон тэдгээрийг арилгаж, хуулийн төслийн уялдаа холбоог сайжруулах зорилгоор хуулийн төслийг бүхэлд нь аргачлалын 4.10-т заасан шалгуурын дагуу аргачлалд заасан асуултад хариулах байдлаар шалгаж үнэллээ.

№	Асуултууд	Хариулт
1	4.10.1.хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх;	Тийм
2	4.10.2.хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх;	Тийм
3	4.10.3.хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томьёотой нийцэж байгаа эсэх;	Тийм
4	4.10.4.хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх;	Тийм
5	4.10.5.хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх;	Үгүй
6	4.10.6.хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг	Тийм

⁹ Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.1-д заасны дагуу 2016 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн Монгол Улсын Засгийн газрын 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан.

	тодорхой тусгасан эсэх;	
7	4.10.7.хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх;	Үгүй
8	4.10.8.хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх;	Үгүй
9	4.10.9.төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх;	Үгүй
10	4.10.10.татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх;	Үгүй
11	4.10.11.тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх;	Хуулийн төсөлд аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалт тусгагдаагүй.
12	4.10.12.Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх;	Үгүй
13	4.10.13.хуулийн төслийн зүйл, заалт жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх;	Тийм
14	4.10.14.хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Үгүй
15	4.10.15.хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Үгүй
16	4.10.16.хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.	Тийм. Хуулийн төсөлтэй уялдуулан Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай дагаж гарах хуулийн төсөл боловсруулсан байна.

Хуулийн төслийн зохицуулалт нь бусад хууль тогтоомжтой нийцэж байгаа ба Үндсэн хуультай зөрчилдөөгүй байна. Түүнчлэн Харилцан үнэлгээний тайлангийн зөвлөмжөөр манай улсад мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог сайжруулах талаар үүрэг хүлээлгэхдээ “үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх”-тэй тэмцэх зохицуулалт бий болгох үүрэг хүлээлгэсэн байна¹⁰.

Үүнтэй холбогдуулан хуулийн зорилт хэсэгт “Энэ хуульд заасан терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх талаарх зохицуулалт үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх аливаа ажиллагаанд нэгэн адил хамаарна” гэж тусгахаар зохицуулсан нь хүчин төгөлдөр үйлчилж буй Мөнгө угаах болон

¹⁰ Монгол Улсын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхтэй тогтолцоонд хийсэн харилцан үнэлгээний тайлан, 4 дүгээр бүлэг, 64-р хуудас, 2017 оны 9 сар

терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн зорилтыг өргөжүүлж манай улс олон улсад хүлээсэн үүргээ биелүүлэх нөхцөлийг бий болгосон байна.

Ийнхүү зохицуулсан нь хуулийн зорилттой болон бусад хууль тогтоомжтой зөрчилдөөгүй байгаагаас гадна энэхүү зохицуулалттай уялдуулан Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Терроризмтой тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар хуулийн төсөл хавсаргасан нь хуулийн уялдаа холбоог хангаж, хэрэгжих нөхцөлийг бий болгож, хуулийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгажээ.

Тухайлбал, Терроризмтой тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих үүргийг хуулиар Тагнуулийн байгууллага хүлээж буйг харгалзан “үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх”-тэй тэмцэх, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих үүргийг тус байгууллагад, “терроризмыг санхүүжүүлэх”-тэй тэмцэх, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих үүргийг Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулиар Санхүүгийн мэдээллийн алба хүлээсэн байгааг харгалзан “үйл олноор хөнөөх зэвсэг дэргэрүүлэхийг санхүүжүүлэх”-тэй тэмцэх үүргийг тус албанд байхаар тусгаж, хуулиар үүрэг хүлээсэн төрийн байгууллага, албан тушаалтнуудын чиг үүрэгт давхардал үүсгээгүй байна.

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх талаар тусгах хуулийн төслийн зохицуулалт нь төрийн тусгай чиг үүрэгтэй холбоотой байгаа учраас төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх боломжгүй байна.

Түүнчлэн хуулийн төслийн үзэл баримтлалд хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ шаардлага, үүнээс үүсэх үр дагаварыг зохицуулах хүрээнд Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Терроризмтой тэмцэх тухай хуулиудыг уялдуулах шаардлагатай талаар дурдсан тул эдгээр хуулиудтай уялдсан байдлыг судалсан.

№	Хуулийн төслөөс:	Уялдаа холбоо
1	Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай: - 29.11 дүгээр зүйл.Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх 1.Монгол Улсын олон улсын гэрээгээр хориглосон хими, биологийн, эсхүл үй олноор хөнөөх бүх төрлийн зэвсгийг боловсруулах, үйлдвэрлэх, хуримтлуулах, олж авах, худалдах үйл ажиллагаанд зарцуулагдахыг мэдсээр байж шууд, эсхүл шууд бусаар эд хөрөнгө хуримтлуулсан, шилжүүлсэн, зарцуулсан бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 2.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж нэг зуун хорин мянган нэгжээс дөрвөн зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.”	Хуультай уялдуулан холбогдох хуульд өөрчлөлтийг тусгахаар дагаж гарах хуулийн төсөл боловсруулсан нь сайшаалтай боловч хуулийн төсөлд “үй олноор хөнөөх зэвсэг, тэдгээрийн түүхий эд, эд зүйл, тоног төхөөрөмж, технологийг” нэмж тусгах, үүнтэй уялдуулан

	- Эрүүгийн хуулийн 29.10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Террорист,” гэснийг “Террорист хүн,” гэж өөрчлөх.	Эрүүгийн хуулийн 29.3-т мөн “үй олноор хөнөөх зэвсэг, тэдгээрийн түүхий эд, эд зүйл, тоног төхөөрөмж, технологийг” нэмэх, эдгээр гэмт хэргийг үйлдсэн хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх зохицуулалт нэмэх шаардлагатай.
2	Терроризмтой тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай: - 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг: “1.2.Энэ хуульд заасан терроризмтэй тэмцэх талаарх бүхий л зохицуулалтад үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхтэй тэмцэх аливаа ажиллагаа нэгэн адил хамаарна.” - 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн 12 дахь заалт: “3.1.12.“үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх” гэж Монгол Улсын олон улсын гэрээгээр хориглосон хими, биологийн, эсхүл үй олноор устгах бүх төрлийн зэвсгийг боловсруулах, үйлдвэрлэх, хуримтлуулах, олж авах, худалдах аливаа үйл ажиллагааг.”	Хуультай уялдуулан холбогдох хуульд өөрчлөлтийг тусгахаар дагаж гарах хуулийн төсөл боловсруулсан байх ба “тэдгээрийн түүхий эд, эд зүйл, тоног төхөөрөмж, технологийг” мөн нэмж тусгах шаардлагатай байна.
3	Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай: - 5.10 дугаар зүйлд нэмэх: 3.Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхээс сэргийлэхтэй холбогдсон аливаа мэдээллийг төрийн холбогдох байгууллагад даруй өгөх, эсхүл террор ажиллагаа, үйлдэлд өдөөн хатгасан аливаа явуулгад автахгүй байх, эсхүл үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхээс сэргийлэх арга хэмжээ, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд дэмжлэг үзүүлэх үүргээ биелүүлээгүй бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. 4.Зохицуулах зөвлөлийн үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхээс сэрэмжлүүлэх талаар өгсөн үүрэг, эсхүл үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх үйлдлийн сөрөг тусгай ажиллагааг удирдах шуурхай	Хуультай уялдуулан холбогдох хуульд өөрчлөлтийг тусгахаар дагаж гарах хуулийн төсөл боловсруулсан байна.

	штабын хүсэлт, шаардлагыг хуулийн этгээд даруй биелүүлэх, эсхүл түүнд бүх талын дэмжлэг, туслалцаа үзүүлэх үүргээ биелүүлээгүй бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” - 11.29 дүгээр зүйлийг өөрчлөн найруулах: 11.29 дүгээр зүйл.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль зөрчих 1.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасны дагуу: 1.1.нэргүй, дугаарласан, хуурамч нэрээр данс нээх, эсхүл гүйлгээ хийх; 1.2.хаагдсан данс ашиглах; 1.3.банк нь халхавч банк, эсхүл халхавч банктai харилцаа тогтоосон банканд данс нээхийг хориглосон журам зөрчсөн бол зөрчилтэй гүйлгээний үнийн дүнтэй тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг хурааж хүн, хуулийн этгээдийг зөрчилтэй гүйлгээний үнийн дүнгийн 30 хувьтай тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. 2.Хуульд заасан харилцагчийг таньж мэдэх, тусгайлан хяналт тавих, гүйлгээний талаар мэдээлэх, харилцагчийн талаархи баримт материалыг хадгалах, сэжигтэй гүйлгээний тухай мэдээлэл, хөрөнгө битүүмжлэх, түдгэлзүүлэхтэй холбоотой үүргийг биелүүлээгүй бол зөрчилтэй гүйлгээний үнийн дүнтэй тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг хурааж хүн, хуулийн этгээдийг зөрчилтэй гүйлгээний үнийн дүнгийн 30 хувьтай тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. 3.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасан: 3.1.дотоод хяналтын хөтөлбөрийг баталж бүртгүүлээгүй; 3.2.шаардлага хангаагүй хүнийг ажилд томилсон; 3.3.мэдээллийн нууцлалыг хадгалах үүргээ хэрэгжүүлээгүй; 3.4.эрх бүхий байгууллагад лавлагаа гаргаж өгөх үүргээс татгалзсан, эсхүл хяналт шалгалтад саад учруулсан бол зөрчилтэй гүйлгээний үнийн дүнтэй тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг хурааж хүн, хуулийн этгээдийг зөрчилтэй гүйлгээний үнийн дүнгийн 30 хувьтай тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	
--	---	--

	4.Гаалийн байгууллагад: 4.1.үнэн зөв мэдүүлэг гаргахаас зайлсхийсэн; 4.2.үнэн зөв мэдүүлэг гаргахаас татгалзсан; 4.3.худал мэдүүлсэн бол зөрчилтэй гүйлгээний үнийн дүнтэй тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг хурааж хүн, хуулийн этгээдийг зөрчилтэй гүйлгээний үнийн дүнгийн 30 хувьтай тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	
--	--	--

ТАВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГӨХ

Үр дүнг үнэлж, зөвлөмж өгөх үе шатыг аргачлалын 5-д заасны дагуу дараахь дарааллаар хийлээ:

- 5.1.үр дүнг баримтжуулах;
- 5.2.үнэлэх;
- 5.3.зөвлөмж өгөх.

5.1.Үр дүнг баримтжуулах: Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг холбогдох шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн бөгөөд холбогдох хууль тогтоомж, бусад эрх зүйн акт болон хамаарал бүхий холбогдох мэдээлэл, тоо баримт зэрэг бусад материалыг ашиглаж, ашигласан материалын жагсаалтыг үнэлгээний тайланд хавсаргаснаас гадна үнэлгээ хийсэн хуулийн төслийг хавсаргасан болно.

Хуулийн төсөл нь дэвшүүлсэн зорилгоо хангасан эсэх, практикт хэрэгжих боломжтой эсэх, хуулийн төслийн найруулга, хэл зүй ойлгомжтой эсэх, бусад хуулиудтай хэрхэн уялдсан гэсэн шалгуур үзүүлэлт тус бүрийн дагуу хийсэн үнэлэлтийг нэгтгэн дараахь дүгнэлтийг хийж, зөвлөмж боловсрууллаа.

5.2.Дүгнэлт: Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх бүх шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн ба шалгуур үзүүлэлт тус бүрээр дүгнэвэл:

✓ **Зорилгод хүрэх байдал:** Хуулийн төслийг зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн үзэл баримтлалд туссан Харилцан үнэлгээний тайлангийн зөвлөмжийн хэрэгжилтийг чиглэгдсэн зохицуулалт хуулийн төсөлд тусгагдсан байна. Тухайлбал, үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэх, түүнийг санхүүжүүлэхийг таслан зогсоох, устгах, урьдчилан сэргийлэх зорилготой санхүүгийн хориг арга хэмжээг хэрэгжүүлэх хууль эрх зүйн орчин бүрдүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх, түүнийг санхүүжүүлэхэд ямар ойлголтыг хамруулах асуудлыг тусгах, гэмт хэрэгт тооцож, эрүүгийн хариуцлага оногдуулах зохицуулалт тусгах, НҮБ-ын Аюулгүйн зөвлөл болон төрийн холбогдох байгууллагаас гаргасан хориг арга хэмжээг хэрэгжүүлэх, мэдээлэх үүрэгтэй этгээдийг зөвлөмжид заасан хүрээнд өргөжүүлэх зэрэг Харилцан үнэлгээний тайланд дурдсан асуудлыг шийдвэрлэхээр зорьсон зохицуулалт хуулийн төсөлд тусжээ.

✓ **Практикт хэрэгжих боломжийг хангасан байдал:** Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалтыг практикт турших ажиллагааг бодитой явуулах нь ихээхэн цаг хугацаа, хөрөнгө шаардахаар байснаас гадна эрчимжүүлсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх 15 сарын хугацаа нь 2018 оны 09 дүгээр сард дуусахаар байгаа, хуулийн төсөл боловсруулж, өргөн мэдүүлэх, батлуулах үе шат нь багагүй хугацаа шаардлагатай байгаа зэргээс үүдэн нь бодит туршилт хийх боломжгүй байсан тул ФАТФ-ын зөвлөмж, албан ёсны мэдээлэл, бусад холбогдох баримт, судалгааг ашиглан судалсан. Ийнхүү судлахад үнэт металл, эсхүл үнэт чулууны болон тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч, хуульч, нотариатч, бусад бие даасан хуулийн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч, нягтлан бодогч нарыг мэдээлэх үүрэгтэй этгээдэд хамруулснаар ФАТФ-ын зөвлөмжийг хэрэгжих нөхцөл, боломжийг бүрдүүлснээс гадна тэдгээрийн үйл ажиллагаанд хэн хяналт тавих асуудлыг тодорхой тусгасан байна. Харин хялбаршуулсан журмаар харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг ямар тохиолдолд хэрэгжүүлэх нь практикт эргэлзээ үүсгэхээр байна. Дотоод хяналтын хөтөлбөр, мэдээлэх үүрэгтэй этгээдийн дотоод хяналтын асуудлыг ФАТФ-ын зөвлөмжид нийцүүлэн, практикт хэрэгжүүлэх, хяналт тавих субъектийг тодорхой зохицуулсан байна.

✓ **Ойлгомжтой байдал:** Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавигдах нийтлэг шаардлага, хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавигдах нийтлэг шаардлагыг хангасан эсэх, зохицуулалтыг хэрэгжүүлэх, хэрэглэх этгээдэд ойлгомжтой байдлаар томъёологдсон эсэхийг хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултад хариулах байдлаар тогтоохоор Хууль тогтоомжийн тухай хуулийн 29, 30 дугаар зүйлд заасан аргачлалын дагуу боловсруулагдсан эсэхийг шалган үнэлсэн. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан зарчимтай зөрчилдөөгүй, түүнийг хангахад чиглэсэн байх бөгөөд бусад хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа хууль тогтоомжтой зөрчилдөөгүй, хуульд заасан шаардлагыг бүрэн хангасан байх ба Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалын дагуу хуулийн төслийг боловсруулж, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Терроризмтой тэмцэх тухай хууль зэрэг холбогдох бусад хуулийг нийцүүлэхээр дагаж гарах хуулийн төсөл боловсруулсан байна.

✓ **Харилцан уялдааг хангасан байдал:** Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг бүхэлд нь аргачлалын 4.10-т заасан асуултад хариулах байдлаар шалгахад хуулийн төслийн зүйл заалт өөр хоорондоо болон Үндсэн хууль, бусад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжтой зөрчилдөөгүй, үүрэг хүлээсэн байгууллага, албан тушаалтнуудын чиг үүрэгт давхардал үүсгээгүй байна. Түүнчлэн хуулийн төсөлтэй уялдуулан Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Терроризмтой тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар дагаж гарах хуулийн төсөл боловсруулсан нь хуулиудын уялдаа холбоог хангах нөхцөлийг бүрдүүлсэн хэдий ч зөвлөмжийн зарим агуулга тусгагдаагүй байна.

5.3.Зөвлөмж:

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Харилцан үнэлгээний тайлантай

холбогдуулан ФАТФ-ын зөвлөмжид заасан стандартыг хангах гол зорилготой байх ба зөвлөмжид нийцүүлэх зохицуулалтуудыг хуулийн төсөлд тусгажээ. Энэхүү хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх ажлын явцад гарсан дараахь асуудлуудыг анхаарч, хуулийн төслийг боловсронгуй болгох, чанарыг сайжруулах чиглэлээр өөрчлөлт оруулах нь зүйтэй гэсэн зөвлөмжийг хууль санаачлагчид өгч байна:

- ✓ Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1.2 дахь хэсэгт “үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх асуудалд хуулийн зохицуулалт хамаарах ба урьдчилан сэргийлэх асуудал хамаарахгүй байх боломжтой мэт байх тул терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх бүхий л зохицуулалтад “үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх” асуудлыг багтаан ойлгохоор илүү тодорхой зохицуулах;
- ✓ Хуулийн төслөөр “үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх” асуудлыг “терроризмыг санхүүжүүлэх” асуудалтай адилтган хуулийн зохицуулалтад хамруулсантай уялдуулан хэрэгжилтэд хяналт тавих субъект нь Санхүүгийн мэдээллийн алба байх тул “үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх” асуудлыг “терроризм”-ын асуудалтай адилтган Терроризмтой тэмцэх тухай хуулийн зохицуулалтад хамруулан тагнуулын байгууллага хяналт тавих талаар дагаж гарах хуулийн төслийг дахин боловсруулах;
- ✓ Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай дагаж гарах хуулийн төслийг дахин боловсруулж, “үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх” гэмт хэргийг тусгах, ийнхүү тусгахдаа “террор үйлдэхийг санхүүжүүлэх” гэмт хэрэгтэй адилтган хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэхээр тусгах;
- ✓ Түүнчлэн “үй олноор хөнөөх зэвсэг”-ээс гадна “тэдгээрийн түүхий эд, материал, эд зүйл, тоног төхөөрөмж, технологи”-ийг хамруулах талаарх өөрчлөлтийг мөн тусгах;
- ✓ Хориг арга хэмжээний жагсаалтад багтсан хүн, хуулийн этгээд, аливаа бүлэг, нэгдэлтэй холбоотой үйл ажиллагаа, ялангуяа санхүүгийн болон ажил хэргийн аливаа үйл ажиллагааг таслан зогсоох, тэдгээртэй холбоотой хөрөнгө, орлогыг цаг алдалгүйгээр царцаах, битүүмжлэх асуудлыг тусгахдаа зөвлөмжид заасан “урьдчилан мэдэгдэлгүйгээр” царцаах, битүүмжлэх талаар тодорхой тусгах;
- ✓ Хуулийн төслийн 5.10 дугаар зүйлийн 5.10.2-т “мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиг үүрэг бүхий олон улсын байгууллагаас мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хяналтын хангалтгүй тогтолцоотой гэж зарлагдсан улсын хүн, хуулийн этгээд”-ийг өндөр эрсдэлтэй харилцагчийн нэг адил авч үзэн харилцагчийг таньж мэдэх нарийвчилсан арга хэмжээ авахаар зохицуулсан байх ба хуулийн төслийн 6¹ дугаар зүйлийн 6^{1.4} дэх хэсэгт “... өндөржүүлсэн харилцагчийг таньж мэдэх арга хэмжээ авах ба шаардлагатай бол хариу арга хэмжээ” авахаар тусгасан нь ойлгомжгүй байдлыг үүсгэхээр байх тул зохицуулалтыг уялдуулах, тодруулбал, харилцагчийг таньж мэдэх нарийвчилсан үйл ажиллагаа, өндөржүүлсэн харилцагчийг таньж мэдэх арга хэмжээ гэдгийг тодорхой болгох;

- ✓ ФАТФ-ын 22, 23 дугаар зөвлөмжид “үнэт металл, эсхүл үнэт чулууны болон тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч нь бэлэн мөнгөний гүйлгээ хийх тохиолдолд” мэдээлэх үүрэгтэй этгээдэд хамаарахаар тусгасан байх тул “аливаа харилцаанд оролцсон” гэснийг “бэлэн мөнгөний гүйлгээ хийсэн” гэж өөрчлөх;
- ✓ Нотариат, хуульч, нягтлан бодогч нь нийтлэг байдлаар бус зөвлөмжид заасан онцгой тохиолдолд мэдээлэх үүрэг хүлээх ба харилцагчийг таньж мэдэх ажиллагаа явуулах ба зөвлөмжид заасныг хуулийн төсөлд тусгахдаа зөвлөмжид дурдсан “manage”, “management” зэрэг үгийг хуулийн төсөлд тусгахдаа “удирдах”, “захиран зарцуулах” гэх зэрэг ялгамжтай үг хэллэг хэрэглэсэн байх тул жигдлэх, түүнчлэн ФАТФ-ын 22 дугаар зөвлөмжийн 22.1.(d)-д “компанийг үүсгэн байгуулах, түүний үйл ажиллагааг явуулах, удирдахад зориулан хөрөнгө татах, бүрдүүлэхийг зохион байгуулах бол” гэснийг “хуулийн этгээдийг үүсгэн байгуулах, түүний үйл ажиллагааг явуулах, удирдах, худалдах, худалдан авах” гэж, “хуулийн этгээд, эсхүл хуулийн дагуу аливаа бүлэг, нэгдлийг үүсгэн байгуулах, түүний үйл ажиллагааг явуулах, удирдах бол, мөн аж ахуйн нэгжийг худалдан авах, худалдах бол” гэснийг “хэлцлийн үндсэн дээр хөрөнгө удирдах, худалдах, худалдан авах бол” гэж агуулгын хувьд алдаатай тусгасныг зөвлөмжид нийцүүлэх;
- ✓ Хуулийн төсөлд хэд хэдэн ажиллагааг нарийвчилсан журмаар зохицуулахаар заан, хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.14 дэх хэсэгт эдгээр журмыг хэн батлах асуудлыг тусгасан ба эдгээр нарийвчилсан журмыг нэгтгэн “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам” нэртэй нэг журам байх зохицуулалтуудын уялдаа холбоог хангах зорилгоор хуулийн төсөлд туссан журмаар зохицуулах талаар туссан зохицуулалтад “хуулийн 5 дугаар зүйлийн 5.14 дэх хэсэгт заасан журамд хамаарах” талаар тусгах;
- ✓ Хуулийн төсөлд хялбаршуулсан харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаа явуулахдаа хуулийн төслийн 5.1.1, 5.1.2-т зааснаар хязгаарлан хэрэглэхээр заасан нь эдгээр заалтын хүрээнд, эсхүл эдгээр заалтаас бусад тохиолдолд эсэх нь ойлгомжгүй байх тул тодорхой тусгах.

ГҮЙЦЭТГЭСЭН: Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар байгуулагдсан Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

I.Хууль тогтоомж, эрх зүйн акт

- 1.Монгол Улсын Үндсэн хууль;
- 2.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль;
- 3.Эрүүгийн хууль;
- 4.Зөрчлийн тухай хууль;
- 5.Терроризмтой тэмцэх тухай хууль;
- 6.Хууль тогтоомжийн тухай хууль;
- 7.Банкны тухай хууль
- 8.Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль
- 9.Нотариатын тухай хууль
- 10.Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- 11.Монгол Улсын Засгийн газрын тогтоол, Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал 2016 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт
- 12.Бактериологийн /биологийн/ болон токсины зэвсэг боловсруулах, үйлдвэрлэх, нөөцлөхийг хориглох, тэдгээрийг устгах тухай конвенц
- 13.Химийн зэвсэг боловсруулах, үйлдвэрлэх, нөөцлөх болон хэрэглэхийг хориглох, түүнийг устгах конвенц

II.Ном, гарын авлага, эмхэтгэл, судалгааны материал

- 1.Хууль тогтоомжийн тухай хууль /аргачлал, гарын авлага/, Улаанбаатар хот, 2016 он;
- 2.Андрей Бергер, Анага Жоши. Үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх: Үзэл баримтлалын удирдамж/аргачлал болон Засгийн газруудад зориулсан загвар хууль, 2017 оны 07 сар
- 3.ФАТФ-ын зөвлөмжийн техникийн хэрэгжилтийг үнэлэх болон мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны үр дүнтэй байдлыг дүгнэх аргачлал, 2013 оны 02 сар
- 4.Ази номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгээс Монгол Улсын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоонд хийсэн Харилцан үнэлгээний тайлан, 2017 оны 09 сар

III. Интернет эх сурвалж

- 1.<http://www.legalinfo.mn>;
- 2.<http://www.mongolbank.mn>;
- 3.<http://www.parliament.mn>;
- 4.<http://www.apgml.org>;
- 5.<http://www.fatf-gafi.com>
- 6.<https://rusi.org>